

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний
зохицуулалтын журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагад мөрдөх “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журам батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 647 дугаар тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын эрхлэх итгэлцлийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”, мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 648 дугаар тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд эрхлэх үлгэрчилсэн багц журам”-ын 9 дүгээр хавсралт “Итгэлцлийн үйлчилгээний үлгэрчилсэн журам”-ыг хүчингүй болсонд тооцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, шийдвэрлүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг үндэслэн “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-д нийцүүлэн итгэлцлийн үйлчилгээнд мөрдөгдөж буй дотоод журам болон итгэлцлийн үйлчилгээний гэрээг шинэчлэн боловсруулж 2008 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ (цаашид “итгэлцлийн үйлчилгээ” гэх) эрхлэхэд учирч болзошгүй санхүү, төлбөрийн чадварын эрсдлээс сэргийлэх, итгэлцлийн үйлчилгээг боловсронгуй болгох, хэлбэрийг тодорхойлох, итгэлцлийн үйлчилгээнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, хяналт тавихад оршино.

1.2. Итгэлцлийн үйлчилгээг Хорооноос тавьсан шаардлагыг хангаж, тус үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллага (цаашид ББСБ гэх) эрхэлнэ.

1.3. ББСБ итгэлцлийн үйлчилгээг эрхлэхдээ Монгол улсын Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ноос баталсан энэхүү журам болон бусад шийдвэрийг удирдлага болгоно.

1.4. Итгэлцлийн үйлчилгээнд талууд бие биедээ харилцан итгэх, үнэнч байх, эрх тэгш, шударга байх, хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмуудыг баримтална.

ХОЁР. Итгэлцлийн үйлчилгээний нэр томъёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг /үр шим/ олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгдэгчээс гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;

2.1.2. “Итгэмжлэгч” гэж өөрийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээдийг;

2.1.3. “Итгэмжлэгдэгч” гэж итгэмжлэгчээс хүлээн авсан бэлэн мөнгө, зээл, бусад активыг түүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үүрэг хүлээсэн, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ББСБ-ыг;

2.1.4. “Хувь хүртэгч” гэж итгэмжилсэн хөрөнгийн ашиг /үр шим/-ийг бүгдийг буюу зарим хэсгийг хүртэхээр хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан гуравдагч иргэн, хуулийн этгээдийг;

2.1.5. “Итгэмжилсэн хөрөнгө” гэж итгэмжлэгчээс итгэмжлэгдэгчид хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу шилжүүлэн өгсөн бэлэн мөнгө, зээл, бусад активыг;

2.1.6. “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” гэж Иргэний хуулийн 406 дугаар зүйл болон энэ журамд заасныг удирдлага болгон итгэмжлэгч, итгэмжлэгдэгчийн хоорондын бичгээр үйлдсэн тохиролцоог.

ГУРАВ. Итгэмжлэгчийн эрх, үүрэг

3.1. Итгэмжлэгч нь дараах эрх эдэлнэ:

3.1.1. Итгэлцлийн үйлчилгээг авах зорилгоор тухайн ББСБ-ын санхүүгийн болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцах;

3.1.2. Иргэний хуулийн 406.3 дахь хэсэгт заасны дагуу өөрийн эрсдлээ ухамсарлаж итгэлцлийн үйлчилгээг авах эсэх шийдвэрээ бие даан гаргах;

3.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш итгэмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл тайлан мэдээг шаардах;

3.1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тохиролцсон ашиг /үр шим/-ийг хүртэхээр шаардах;

3.1.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;

3.1.6. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнээс үүдэн гарсан аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

3.2. Итгэмжлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

3.2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгийг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлэх;

3.2.2. Итгэмжлэгдэгчид шилжүүлсэн хөрөнгийн талаар болон итгэлцлийн үйлчилгээг авахтай холбоотойгоор итгэмжлэгдэгчээс шаардсан холбогдох мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх;

3.2.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгдэгчид төлөх;

3.2.4. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой итгэмжлэгдэгчээс гарсан зайлшгүй зардлыг төлөх;

3.2.5. Итгэмжилсэн хөрөнгийн ашиглалтын талаар хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд зааснаас өөр аливаа зааварчилгаа өгөхгүй байх;

3.2.6. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВ. Итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг

4.1. Итгэмжлэгдэгч нь дараах эрх эдэлнэ:

4.1.1. Итгэлцлийн үйлчилгээг үзүүлсний төлөө авахаар хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгчээс шаардах;

4.1.2. Итгэмжилсэн хөрөнгийг ашигласантай холбоотойгоор гарсан зайлшгүй зардлыг итгэлцлийн хөрөнгөөс гаргуулах;

4.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээтэй холбоотой гарсан аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.4. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2. Итгэмжлэгдэгч нь дараах үүрэг хүлээнэ:

4.2.1. Итгэлцлийн үйлчилгээг авахаар хандсан этгээдэд өөрийн компанийн санхүүгийн байдал болон итгэлцлийн хөрөнгийг зарцуулах зориулалтын талаар үнэн зөв мэдээлэл гаргаж өгөх;

4.2.2. Итгэмжилсэн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

4.2.3. Итгэмжилсэн хөрөнгийн эх үүсвэрийг гагцхүү хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу болон Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд захиран зарцуулах;

4.2.4. Итгэмжилсэн хөрөнгийн ашиглалтын талаар тодорхой, үнэн зөв бүртгэл хөтөлж, тайлан гаргах, шаардсан тохиолдолд итгэмжлэгчид гаргаж өгөх;

4.2.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэлцлийн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой үүссэн үүргийг гуравдагч этгээдийн өмнө биечлэн хариуцах;

4.2.6. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд нэгээс дээш хувь хүртэгчтэй байхаар заасан тохиолдолд үр шим, ашиг хүртэх хувиас үл хамааран тэдэнд адил тэгш хандах;

4.2.7. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрөөр заагаагүй бол бичгээр гаргасан хүсэлтийн дагуу итгэмжилсэн хөрөнгө ашиглахтай холбоотой мэдээллийг хувь хүртэгчид гаргаж өгөх;

4.2.8. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тохиролцсоны дагуу итгэмжлэгч буюу хувь хүртэгчид ашиг /үр шим/-ийг хүртээх;

4.2.9. Итгэлцлийн үйлчилгээний дотоод журмыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

4.2.10. Итгэмжлэгдэгчийн гүйцэтгэх удирдлага нь тухайн ББСБ-ын цорын ганц хувь нийлүүлэгч биш тохиолдолд итгэлцлийн үйлчилгээгээр хүлээн авсан хөрөнгийн хэмжээ,

хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын талаар бусад хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх;

4.2.11. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ажиллах;

4.2.12. Сар бүрийн 10-ны өдрийн дотор энэхүү журмын хавсралтын дагуу гаргасан итгэмжилсэн хөрөнгийн тайлан судалгаа, ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Хороонд ирүүлэх;

4.2.13. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ТАВ. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага

5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу итгэмжлэгдэгчийн нийт итгэмжлэгчээс татсан хөрөнгийн хэмжээ нь Хорооноос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээтэй уялдуулан тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа 6 сараас дээш байх ба нэрлэсэн ашиг /үр шим/-ийг зарлахгүй, зөвхөн хувь хүртэгчийн хүртэж болох ашиг /үр шим/-ийн хэмжээг тусгасан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 346 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

5.3. Итгэмжлэгдэгч нь итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр болох хөрөнгийг даатгуулж болно.

5.4. Итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ нь итгэлцлийн үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдол бүрт хувийн хэрэг бүрдүүлнэ.

5.5. Энэ журмын 5.4-т заасан хувийн хэрэг дараах бичиг баримтаас бүрдэнэ:

5.5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;

5.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу хийсэн төлбөр тооцооны баримт;

5.5.3. Итгэмжлэгчийн анкет;

5.5.4. Шаардлагатай бусад баримт бичиг, мэдээллүүд.

5.6. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ нь 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, сүүлийн 4 улирал дараалан ашигтай ажилласан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 346 дугаар тогтоолоор нэмсэн/

ЗУРГАА. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад хориглох зүйл

6.1. Дараах үйл ажиллагаа явуулахыг итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-д хориглоно:

6.1.1. Хорооноос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ нь итгэмжлэгчийг татах зорилгоор олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, сурталчилгаа явуулах, ашиг /үр шим/ олгох талаар олон нийтэд урьдчилан амлах;

6.1.2. Итгэмжилсэн хөрөнгийг Хорооноос зөвшөөрөл аваагүй бусад санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулах;

6.1.3. Итгэмжлэгдэгч нь итгэмжилсэн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тогтоосон нөхцөлийг зөрчиж итгэмжлэгч болон хувь хүртэгчийн хууль бус ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах;

6.1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах хүсэлтэй итгэмжлэгчийн санал болгож байгаа нөхцөл, шаардлагыг итгэмжлэгдэгчийн эрх ашигт албадан нийцүүлэх аливаа оролдлого хийх;

6.1.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр татсан хөрөнгийг бусад этгээдэд итгэлцлийн үйлчилгээгээр шилжүүлэх;

ДОЛОО.Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ
байгуулах, дуусгавар болох

7.1. Хорооноос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ болон түүнд итгэл хүлээлгэсэн итгэмжлэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулна.

7.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг Иргэний хуулийн 406 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулна.

7.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд дараах зүйлийг заавал тусгасан байна:

7.3.1. а/итгэмжлэгч нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;

б/итгэмжлэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас, тухайн хуулийн этгээдийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах албан тушаалтны овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;

7.3.2. Итгэмжлэгдэгчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;

7.3.3. а/ хувь хүртэгч нь иргэн бол тэдгээрийн овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;

б/ хувь хүртэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас, тухайн хуулийн этгээдийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах албан тушаалтны овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;

7.3.4. Итгэмжлэгчээс итгэмжлэгдэгчид шилжүүлэх хөрөнгийн хэмжээ;

7.3.5. Итгэмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах зориулалт;

7.3.6. Гэрээний хугацаа;

7.3.7. Итгэлцлийн үйлчилгээгээр ашиг /үр шим/ олохоор тохиролцсон бол түүний хэмжээ;

7.3.8. Хэрэв хувь хүртэгч байгаа бол түүний хүртэж болох ашиг /үр шим/-ийн хэмжээ;

7.3.9. Нэгээс дээш хувь хүртэгчтэй бол хувь хүртэгч тус бүрт хүртээж болох ашиг /үр шим/-ийн хэмжээ;

7.3.10. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлсний төлөө гарах зайлшгүй зардал, түүнийг хэрхэн шийдвэрлэх;

7.3.11. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлсний төлөө итгэмжлэгдэгчийн авах хөлсний хэмжээ;

7.3.12. Итгэмжлэгчийг итгэлцлийн үйлчилгээний явц болон холбогдох мэдээллээр хэрхэн хангах;

7.3.13. Хэрэв хувь хүртэгчид ашиг /үр шим/-ийг олгохоор заасан бол хувь хүртэгчийн эрх, үүрэг;

7.3.14. Итгэлцлийн үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;

7.3.15. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тохирсон ашиг /үр шим/-ийг олоогүй, итгэмжилсэн хөрөнгө үрэгдэж үгүй болсон буюу дутсан нь итгэмжлэгдэгчийн гэм буруугаас болсон бол итгэмжлэгдэгч хариуцлага хүлээх тухай;

7.3.16. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тохирсон ашиг /үр шим/-ийг олоогүй, итгэмжилсэн хөрөнгө үрэгдэж үгүй болсон буюу дутсан нь давагдашгүй хүчин зүйлээс болсон бол энэ тухай итгэмжлэгчид мэдээлэх, эрсдлийг хэрхэн хуваарилах нөхцөл;

7.3.17. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ дуусгавар болгох нөхцөл;

7.3.18. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад нөхцөл.

НАЙМ. Нягтлан бодох бүртгэлд тусгах

8.1. ББСБ нь итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой гүйлгээг Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-д заасны дагуу хийж гүйцэтгэж, нягтлан бодох бүртгэлд бүртгэнэ.

ЕС. Итгэлцлийн үйлчилгээнд тавих хяналт

9.1. Итгэмжилсэн хөрөнгийг нь хууль тогтоомж болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу захиран зарцуулж байгаа эсэхэд итгэмжлэгч хяналт тавина.

9.2. Итгэмжилсэн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу хувь хүртэгч /хүртэгчид/-д ашиг /үр шим/ ногдож байгаа эсэхэд итгэмжлэгдэгчийн ТУЗ, Дотоод хяналтын алба болон Хорооноос дараалсан хяналтыг тавьж хэрэгжүүлнэ.

9.3. Хороо нь ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг итгэмжлэгдэгч хангаж байгаа эсэхийг сар тутмын санхүүгийн тайлангаар тогтоох ба шаардлагатай гэж үзвэл газар дээрх шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээ авна.

АРАВ. Хариуцлага

10.1. Итгэмжлэгдэгч нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, цаашид болзошгүй эрсдэл үүсэх магадлалтай болсон нөхцөлд Хорооноос дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

10.1.1. ББСБ-ын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавих;

10.1.2. Итгэлцлийн үйлчилгээгээр эх үүсвэр нэмж татан төвлөрүүлэхийг хориглох;

10.1.3. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

10.1.4. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

10.2. Итгэлцлийн үйлчилгээг эрхлэхдээ энэхүү журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

10.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль тогтоомжийг мөрдөөгүйгээс үүссэн хохирол, итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой гарсан аливаа маргааныг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн эрх бүхий хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

-- ооОоо --

ББСБ-ЫН ИТГЭМЖИЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

..... БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

20.... оны -р сар

/төгрөгөөр/

Д/д	Итгэмжлэгчийн нэр	Хувь хүртэгч /хүртэгчид/-ийн нэр	Хөрөнгийн хэмжээ	Зориулалт	Хөрөнгө шилжүүлж авсан огноо	Хөрөнгө буцаан олгох огноо	Хугацаа сунгасан олгох огноо	Хувь хүртэгчийн хүртэх/хүртсэн ашгийн хэмжээ	Итгэмжлэгчээс төлсөн хөлсний хэмжээ	Итгэмжлэгч ээс гаргасан зардлын хэмжээ	Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх хувь хэмжээ
	БҮГД										

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ НЭР

